ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.24 № 2/93

танай ____________-ны №____________-т

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ДУГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ У.САРУУЛЗАЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Энэ хичээлийн жилд “Эх хэл бичиг” кабинет төсөл, “Бүтээлч төгөл” зэрэг 10.0 сая төгрөгийн 2 төсөл хэрэгжүүлэн ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Тус сургууль нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан бол тайлант оны эхний 3 сард тогтмол зардлын санхүүжилтийг орон нутгаас, сүүлийн саруудын санхүүжилтийг улсын төсвөөс авсан онцлогтой байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 19.9 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сургууль нь 2189 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 2022 онд 67 бүлэгт 2230 хүүхэдтэйгээр 89 багштай, 124 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 онд 4 зорилт 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ.

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 30 бүлэгт нийт 165410 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 247.1 сая төгрөгийг зарцуулжээ.

021020336

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **218,338,827.37** | **244,142,518.56** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 19,866,015.01 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 19,866,015.01 |
| **3121** | **Төгрөг** | - | 19,866,015.01 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 19,866,015.01 |
| **33** | **АВЛАГА** | 643,205.87 | 8,102,139.49 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 643,205.87 | 8,102,139.49 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 200,000.00 | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 200,000.00 | - |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 200,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 217,495,621.50 | 216,174,364.06 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,142,554.53 | 2,042,554.53 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | |
| 35130 | Эм боох материал | 2,142,554.53 | 2,042,554.53 |
| **354** | **Хангамжийн материал** | 215,353,066.97 | 214,131,809.53 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 667,600.00 | 950,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 32,089,130.00 | 32,163,078.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 182,596,336.97 | 176,415,709.97 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 4,602,421.56 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,385,552,125.95** | **3,382,360,804.51** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,385,552,125.95 | 3,382,360,804.51 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,786,746,125.95 | 2,783,554,804.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,098,812,520.66 | 3,098,812,520.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (508,771,084.09) | (657,454,646.65) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 366,140,654.29 | 511,688,836.29 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (302,623,947.36) | (318,893,248.52) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 183,128,784.00 | 211,452,766.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (111,306,705.62) | (136,909,445.34) |
| 39217 | Ном | 61,365,904.07 | 74,858,022.07 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 598,806,000.00 | 598,806,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,204,860.00 | 1,204,860.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,204,860.00) | (1,204,860.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 598,806,000.00 | 598,806,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,603,890,953.32** | **3,626,503,323.07** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,207,498.60** | **2,486,176.60** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,207,498.60 | 2,486,176.60 |
| **413** | **Өглөг** | 1,207,498.60 | 2,486,176.60 |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | 1,207,498.60 | 2,486,176.60 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,180,977.60 | 2,401,176.60 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 26,521.00 | 85,000.00 |
| 41363 | Татварын өглөг /ТӨУГ/ | | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,602,683,454.72** | **3,624,017,146.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,602,683,454.72 | 3,624,017,146.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,472,498,973.00 | 1,472,498,973.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,040,809,950.54 | 1,062,143,642.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,040,809,950.54 | 1,040,809,950.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 21,333,691.75 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,089,374,531.18 | 1,089,374,531.18 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,603,890,953.32** | **3,626,503,323.07** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2.557.855.254.07** | **3.438.857.603.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **125,557,354.07** | **113,938,303.56** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 125,557,354.07 | 103,938,303.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 25,264,618.07 | 95,341,003.56 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 535,000.00 | 3,211,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 24,729,618.07 | 92,130,003.56 |
| 120009 | Бусад орлого | 100,292,736.00 | 8,597,300.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 10,000,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 10,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,432,297,900.00** | **3,324,919,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,133,950,700.00 | 2,914,803,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,133,950,700.00 | 2,914,803,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 1,665,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,665,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 298,347,200.00 | 408,450,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 298,347,200.00 | 408,450,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,697,596,832.58** | **3,415,218,615.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,697,596,832.58** | **3,415,218,615.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,578,919,056.58 | 3,167,873,664.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,821,653,702.20 | 2,216,199,986.27 |
| 210101 | Үндсэн цалин | 1,821,653,702.20 | 2,216,199,986.27 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 226,318,283.52 | 279,009,862.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 153,921,565.60 | 190,453,065.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,108,419.48 | 22,139,199.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,486,735.59 | 17,711,359.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,618,323.89 | 4,427,839.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,183,238.96 | 44,278,398.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 293,275,875.00 | 336,155,449.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,351,800.00 | 24,394,529.00 |
| 210302 | Түлш, халаалт | 233,065,300.00 | 263,092,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 46,858,775.00 | 48,668,280.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,630,690.00 | 103,772,345.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,742,310.00 | 21,971,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,567,880.00 | 1,500,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 197,100.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 368,200.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,755,200.00 | 8,924,626.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 71,376,119.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,912,654.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,324,754.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,587,900.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,124,600.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 6,124,600.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 552,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 552,000.00 | - |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,684,600.00 | 13,389,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,475,000.00 | 8,597,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,209,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,791,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 205,766,651.86 | 219,346,821.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,248,700.00 | 24,040,644.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,736,450.00 | 4,750,574.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 193,781,501.86 | 190,555,603.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 118,677,776.00 | 247,344,951.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 118,677,776.00 | 247,105,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 77,872,100.00 | 247,105,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 40,805,676.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 239,551.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 239,551.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(139,741,578.51)** | **21,333,691.75** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(139,741,578.51)** | **21,333,691.75** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,533,125,636.00** | **3,346,727,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **100,827,736.00** | **21,808,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 100,827,736.00 | 11,808,300.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 535,000.00 | 3,211,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 535,000.00 | 3,211,000.00 |
| 120009 | Бусад орлого | 100,292,736.00 | 8,597,300.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 10,000,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 10,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,432,297,900.00** | **3,324,919,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,133,950,700.00 | 2,914,803,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,133,950,700.00 | 2,914,803,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 1,665,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,665,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 298,347,200.00 | 408,450,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 298,347,200.00 | 408,450,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,533,125,636.00** | **3,326,861,584.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,533,125,636.00** | **3,326,861,584.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,416,031,360.00** | **3,079,516,633.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,784,197,685.00 | 2,226,340,799.99 |
| 210101 | Үндсэн цалин | 1,097,214,540.00 | 1,595,854,713.77 |
| 210102 | Нэмэгдэл | 601,910,845.00 | 591,690,519.41 |
| 210104 | Урамшуулал | 85,072,300.00 | 38,795,566.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 245,605,415.00 | 278,292,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 174,148,315.00 | 189,238,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,914,200.00 | 22,139,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,331,500.00 | 17,934,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,582,900.00 | 4,452,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,628,500.00 | 44,526,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 294,226,400.00 | 336,155,449.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,615,800.00 | 24,394,529.00 |
| 210302 | Түлш, халаалт | 233,065,300.00 | 263,092,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 49,545,300.00 | 48,668,280.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,568,160.00 | 1,500,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,410,460.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,803,900.00 | 1,500,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,021,500.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,286,200.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,046,100.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 5,900,400.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,059,300.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,841,100.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,993,200.00 | 2,493,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,993,200.00 | 2,493,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 667,600.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 667,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,809,600.00 | 28,083,950.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,600,000.00 | 8,597,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,209,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 19,486,650.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,062,900.00 | 206,650,935.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,000,000.00 | 170,838,779.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 44,062,900.00 | 35,812,156.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,094,276.00** | **247,344,951.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 117,094,276.00 | 247,105,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 76,288,600.00 | 247,105,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 40,805,676.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 239,551.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 239,551.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **19,866,015.01** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 19,866,015.01 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 19,866,015.01 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1472498973 | 1089374531.18 | 1040809950.54 | 3602683454.72 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1472498973 | 1089374531.18 | 1040809950.54 | 3602683454.72 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1472498973 | 1089374531.18 | 1040809950.54 | 3602683454.72 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 21333691.75 | 21333691.75 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1472498973** | **1089374531.18** | **1062143642.29** | **3624017146.47** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3334135200.00** | **3316861584.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3334135200.00 | 3316622033.99 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3074721900.00 | 3069516633.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2226340800.00 | 2226340799.99 |
| 210101 | Үндсэн цалин | 1652907600.00 | 1595854713.77 |
| 210102 | Нэмэгдэл | 526165300.00 | 591690519.41 |
| 210104 | Урамшуулал | 47267900.00 | 38795566.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 278292300.00 | 278292300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 189238900.00 | 189238900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22139700.00 | 22139700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17934300.00 | 17934300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4452700.00 | 4452700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 44526700.00 | 44526700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 336395000.00 | 336155449.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21615800.00 | 24394529.00 |
| 210302 | Түлш, халаалт | 264733900.00 | 263092640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50045300.00 | 48668280.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 1500000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,493,200.00 | 2,493,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,493,200.00 | 2,493,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,490,800.00 | 28,083,950.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,615,900.00 | 8,597,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 23,874,900.00 | 19,486,650.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 198,709,800.00 | 196,650,935.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 162,897,400.00 | 160,838,779.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 35,812,400.00 | 35,812,156.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 259,413,300.00 | 247,105,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 259,413,300.00 | 247,105,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 259,413,300.00 | 247,105,400.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 239,551.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 239,551.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3334135200.00** | **3,336,727,600.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,925,684,800.00 | **2,916,468,900.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,925,684,800.00 | 2,914,803,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 1,665,000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 408,450,400.00 | **408,450,400.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 408,450,400.00 | 408,450,400.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | **11,808,300.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 11,808,300.00 |
| **122** | **Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих** | | - |
| **122** | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **19,866,015.01** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 124.00 | 124.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 99.00 | 99.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 24.00 | 24.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 2,230.00 | 2,230.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 2,230.00 | 2,230.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 2,230.00 | 2,230.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **124.00** | **124.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 98.00 | 98.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 25.00 | 25.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **10.000.000.00** | **-10.000.000.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **0.00** | **10.000.000.00** | **-10.000.000.00** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **0.00** | **10.000.000.00** | **-10.000.000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **10.000.000.00** | **-10.000.000.00** |
| 131101 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | **10.000.000.00** | **-10.000.000.00** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Ховд аймгийн Жаргалант сумын Нэгдүгээр сургууль нь 2022 оны хичээлийн жилийг "Хүүхдийн хөгжлийг дэмжиж, амжилттай сургахад эцэг, эхийн болон бусад хамтын ажиллагаа, оролцоог хангаж, сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, эх хэл бичиг, түүхээ дээдэлсэн бүтээлч суралцагчийг төлөвшүүлнэ" гэсэн зорилго тавин 3 чиглэлийн хүрээнд 9 зорилт дэвшүүлж 79 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ.

Нэгдүгээр сургууль нь 4 заах аргын нэгдэлд сургалт бусад үйл ажиллагаа явуулдаг ба байгалийн ухааны заах аргын нэгдэлд 31, нийгмийн ухааны заах аргын нэгдэлд 28, бага ангийн заах аргын нэгдэлд 30, захиргаа аж ахуйн заах аргын нэгдэл 35 нийт 124 багш ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус сургууль нь бага ангийн 30, дунд, ахлах ангийн 59 багштай. Зөвлөх багш 9, тэргүүлэх зэрэгтэй багш 38, заах аргач багш 26, зэрэггүй 16, нийт багш нарын 82% нь мэргэжлийн зэрэгтэй, 71 багш бакалавр, 18 багш магистр зэрэгтэй байна. Нийт багш нар 100% багшлах эрхтэй.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшний багш 0, II түвшний багш 0, III түвшний багш 1, бусад багш нар IV 11 түвшинд шалгагдсан ба нийт оноогоор 32.6% авч аймгийн дунджаас 3.7%, улсын дунджаас 1.1% ахисан амжилтыг үзүүллээ.

Жаргалант сумын нэгдүгээр сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 250 сурагч элсэж, 66 бүлэгт 2250 сурагч суралцаж, анги дүүргэлтийн дундаж 34 ба бага анги буюу 1-5 дугаар ангийн 30 бүлэгт 1188, дунд анги буюу 6-9 дүгээр ангийн 23 бүлэгт 755, ахлах анги буюу 10-12 дугаар ангийн 13 бүлэгт 307 сурагч суралцаж байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд Боловсролын тухай хуульд 3 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд 2 удаагийн өөрчлөлт оржээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын нэгдүгээр сургуулийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны А/51 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Байгууллагын даргын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/64 тоот тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулагдаж байгууллагын гадаад, дотоод орчинд тавигдах шаардлагын хүрээнд хүрээнд 27 эрсдэлийг илрүүлэн гадаад орчныг өндөр эрсдэлтэй, дотоод орчин эрсдэл бага үнэлэгдсэн байна. Сургуулийн эзэмшил газрын талбайн өндрөөс биет унах эрсдэлтэй хэсэгт хамгаалалтын бүс тогтоож анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулаагүй, анги танхимын агаар сэлгэлтийн хоолой төхөөрөмжид шинэчлэл үйлчилгээ хийгдээгүй, сангийн урсгал засвар хийгдээгүйн хүүхэд сурах орчинд сөрөг нөлөө үзүүлсэн гэм мэт шалтгаан нөлөөлсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын нэгдүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.6 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 19,866,015.01 | 19,866,015.0 |
| Авлага | 843,205.9 | 8,102,139.5 | 7,258,933.6 |
| Бараа материал | 217,495,621.5 | 216,174,364.06 | (1,321,257.4) |
| Үндсэн хөрөнгө | 3,385,552,126.0 | 3,382,360,804.51 | (3,191,321.4) |
| **Нийт хөрөнгө** | **3,603,890,953.3** | **3,626,503,323.7** | **22,612,369.8** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,603,890,953.3 | 3,626,503,323.7 | 22,612,369.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,603,890,953.3** | **3,626,503,323.7** | **22,612,369.8** |

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Жаргалант сумын Нэгдүгээр сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.6 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой бөгөөд балансын үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 19.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Тайлант онд 100.9 сая төгрөгийн бараа материал авч, 102.3 сая төгрөгийн материал зарцуулж үлдэгдэл 1.3 сая төгрөгөөр буурсан.
- ✓ Байгууллагын хөрөнгөөр 119.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 67.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авч тайлант хугацаанд 190.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсантай холбоотой 3.2 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,150.0 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 0.6 сая , орон нутгийн төсвөөс 431.0 сая нийт зарлагыг 3,581.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 2,916.4 сая, орон нутгийн төсвөөс 408.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 11.8 сая, төслийн нэмэлт санхүүжилт 10.0 сая төгрөг нийт 3,346.7 сая төгрөг гүйцэтгэлээр санхүүжиж 3,316.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 19.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,316.8 сая төгрөг 99.4 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71802/80226-тогтмол зардал | 336,395.00 | 336,155.40 | 239.60 | 99.9% |
| 2 | 71802/80312-бараа үйлчилгээ | 193,533.10 | 200,644.20 | -7,111.10 | 104% |
| 3 | 70802/81801 -үдийн цай | 259,413.30 | 247,345.00 | 12,068.30 | 95% |
| 4 | 70802/81605-Эрүүл мэнд | 278,292.30 | 278,292.30 | 0.00 | 100% |
| 7 | 71802/81834-Үндсэн цалин | 2,226,340.80 | 2,226,340.80 | 0.00 | 100% |
| 10 | 71802/81848 сурах бичгийн түрээс | 8,615.90 | 8,597.30 | 18.60 | 100% |
| 11 | 71802/80111-тогтмол зардал | 23,874.90 | 19,486.60 | 4,388.30 | 99% |
| 12 | 71802/80112-нийтлэг үйлчилгээ | | | 0.00 | 0% |
| **ДҮН** | | **3,326,465.30** | **3,316,861.60** | 9,603.70 | 98% |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төслийн 10.0 сая төгрөг орж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Энхжаргал 2023 оны 02 дугаар сарын 10-ний өдрөөс 02 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,415.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 51.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 40.1 сая төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой гар утасны зардалд 1.5 сая төгрөгийн зардал гарсан ба энэ нь 61 багш нарын дата хэрэглээнд Боловсрол шинжлэх ухааны сайдын баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах журмын дагуу зарцуулагдсан байна.

14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалтын хүрээнд 89.3 сая төгрөгийн таблет, зөөврийн компьютер, толгой компьютерын худалдан авалт хийсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй, байсныг аудитын явцад залруулан мэдээлүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Хатан түнгэл ХХК-тай хийсэн үдийн цайны тооцоо, сурах бичгийн түрээсийн орлогын тооцоог анхаарах хэрэгтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.3 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 2.3 сая төгрөгийн алдааг залруулав.Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд 2.3 сая төгрөгийн авлага бүртгэн тайлагнасан. Гэтэл байгууллагын нягтлан бодогч 2022 оны 12 сард ажлаас чөлөөлөгдөж, шинэ нягтлан бодогч томилогдон зөрүүтэй авлага бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 21.6 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 4 заалт бүхий 20.9 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

- Тайлант онд сургалт зохион байгуулсан багш нарт олгосон 2.6 сая төгрөгийн хөлснөөс 0.6 сая төгрөгийн НДШ тооцоогүй нь *Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 32 дугаар зүйлийн 32.1 дахь заалтыг зөрчсөн байна.*

### 5.2 Зөвлөмж

#### *5.2.1 Сурах бичгийн түрээсийн орлоготой холбоотой асуудал*

***Илрүүлэлт.*** *Хичээлийн жилд сурагчдад түрээсэлсэн сурах бичгийн түрээсийн орлого 8.5 сая төгрөгийг хувийн дансаар цуглуулан, тооцоо нийлээгүй байгаа нь Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2019 оны 5 дугаар сарын 19-ний "Журам батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 3.2 дахь заалт "Төлбөрийг төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн суралцагч сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд тушаана" гэсэн заалтыг хангаагүй байна.*

***Өгсөн зөвлөмж:*** *Сайдын тушаалаар баталсан журмын дагуу сурах бичгийн түрээсийн орлогыг суралцагч бүр сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн тооцоог тухай бүрд нь хийж, хувь хүний дансаар авсан зөрчлийг давтан гаргахгүй ажиллах*

#### *5.2.2 Сурагчдын үдийн цайны зардалтай холбоотой асуудал*

*Хатан түнгэл ХХК-д шилжүүлсэн сурагчдын үдийн цайны зардлын анхан шатны баримт дутуу,цахим ирцийн бүртгэлтэй тулгаж баталгаажуулаагүй, тооцоо нийлсэн акт иу бүрэн бус байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

***Өгсөн зөвлөмж:*** *Хатан түнгэл ХХК-д шилжүүлсэн үдийн цайны зардлын дутуу байгаа анхан шатны баримтыг иж бүрэн болгож дотоод хяналт хэрэгжүүлэн сургуулийн бага*

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ангийн сурагчдад олгож байгаа үдийн цайны санхүүжилтийг гэрээ бүхий байгууллагад шилжүүлэхдээ цахим бүртгэлтэй тулган баталгаажуулж анхан шатны баримтыг бүрдүүлэх, сар бүр тооцоо нийлж байх

### 5.2.3 Өглөг авлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт: Эй Плас Интернэйшнл ХХК-д 2 удаагийн гүйлгээгээр 11.3 сая төгрөгийг анхан шатны барим дутуу сургалтын зардал шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудтай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж: Сургалтын төлбөрт Эй Плас Интернэйшнл ХХК-д шилжүүлсэн 11.3 сая төгрөгийн анхан шатны баримтыг бүрдүүлэн баримтад хавсаргах, цаашид анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийхгүй байх*

### 5.2.4 Хөрөнгө данс бүртгэлд бүртгэх талаар

*Илрүүлэлт: Тайлант онд хэрэгжүүлсэн 5.0 сая төгрөгийн өртөг бүхий "Бүтээлч төгөл" төслийн санхүүжилтээр Арина электроникс ХХК-с авсан 1.0 сая төгрөгийн үнэтэй JPE 50 зурагтыг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалтыг бүртгэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж : Данс бүртгэлд тусгаагүй 1.0 сая төгрөгийн хөрөнгийг дансанд бүртгэж орлого авах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| авлага илүү бүртгэсэн | 1 | 2,305.1 | | | | | 1 | 2,305.1 | | | | |
| Дүн | **2** | **2,305.1** | | - | | | **2** | **2,305.1** | **0** | **0** | **0** | **0** |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сургалт зохион байгуулсан багш нарт олгосон хөлснөөс шимтгэл тооцоогүй | 1 | 631.2 | 1 | 631.2 | - | - | - | - | - | - | - | - |
| Эй Плас Интернэйшнл ХХК-д 2 удаагийн гүйлгээгээр шилжүүлсэн | 1 | 11,280.0 | | | | | 1 | 11,280.0 | - | - | - | - |
| Сурах бичгийн түрээсийн орлого хувь хүний дансаар авсан | 1 | 8,597.3 | | | 1 | - | 1 | 8,597.3 | - | - | - | - |
| Үдийн цайны тооцоо иж бүрэн бус | 1 | - | - | - | | | 1 | | - | - | - | - |
| Төслийн санхүүжилтээр авсан зурагт хөрөнгөөр бүртгээгүй | 1 | 1,080.8 | | | | | 1 | 1,080.8 | | | | |
| Дүн | 5 | 21,589.3 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 20,958.1 | | | - | - |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **[illegible].БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР:** **Д.ЭНХЖАРГАЛ**